UNITED NATIONS MONGOLIA

Japanese Funds-in-Trust



## НҮБ–ын Хүний аюулгүй байдлыг хангах итгэлцлийн сан

# НҮБ–ын хамтарсан төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН АМЬДРАЛЫН БАТАЛГААГ НИЙГМИЙН ИЖ БҮРЭН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ХАНГАХ НЬ

Тэдний ирээдүйг баталгаажуулъя



## Монгол Улсын Шадар сайд
## М.Энхболд

Монгол улс нь өргөн уудам нутаг дэвсгэртэй, харьцангуй цөөн хүн амтай бөгөөд тэдний соёл заншил нь нүүдэлчин уламжлал, ахуйгаас улбаатай юм. Монгол улсын хүн амын дийлэнх хэсгийг халх монголчууд эзэлж, үлдсэн хувийг барга, баяд, буриад, дөрвөд, цаатан зэрэг угсаатны цөөнх хүн ам эзэлдэг. Түүнчлэн исламын шашин шүтлэгтэй казах үндэстэн Монгол улсын баруун хязгаар нутагт төвлөрөн амьдарч, тэдний дунд ивэнх, тува, урианхай зэрэг өөр хэл, аялга бүхий угсаатнууд амьдардаг.

Монгол Улсын Их Хурлаас “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг 2008 оны нэгдүгээр сард баталсан бөгөөд уг бодлогод үндэстэн /угсаатны цөөнх хүн амын хэрэгцээг тодорхойлон тэдний соёлын асуудлаарх эрхийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх стратеги тусгалаа олсон байдаг. Монгол улсын алслагдсан хөдөөгийн хүн ам, тодруулбал үндэстэн/угсаатны цөөнх хүн амын аж байдлыг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт НҮБ дэмжлэг үзүүлсээр ирсэн бөгөөд 2009 оны 6 дугаар сараас эхлэн Монгол улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болох НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ хамтран НҮБ-ын Хүний аюулгүй байдлыг хангах итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсын Хөдөөгийн хүн амын амьдралын баталгаар нийгмийн иж бүрэн үйлчилгээгээр хангах” төслийг хэрэгжүүлж байна.

Төслийн үр дүнд Монгол улсын алслагдмал хөдөө орон нутгийн хүн амд үзүүлэх нийгмийн иж бүрэн үйлчилгээг сайжруулах арга замыг оновчтой тодорхойлон, тэдний амьжиргааг дэмжиж, ядуурлыг бууруулахад бодитой алхам хийгдэнэ хэмээн найдаж байна.



## НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагын Бээжин хот дах Суурин төлөөлөгчийн газрын Захирал бөгөөд Суурин төлөөлөгч А.Сингх

НҮБ нь Монгол Улсын Засгийн газарт Мянганы хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэх, түүнчлэн Монгол Улсын иргэд нийгэм, эдийн засгийн хувьд сайн сайхан, аюулгүй, баталгаатай амьдрах нөхцлийг баталгаажуулахад дэмжлэг үзүүлсээр ирсэн.

НҮБ-ын Хүний аюулгүй байдлыг хангах итгэлцлийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй хамтарсан төсөл нь Монгол Улсын хөдөө орон нутагт амьдарч байгаа үндэстэн/угсаатны цөөнх хүн амын мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах болон иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлнэ. Тухайлбал, НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага хөдөө орон нутагт амьдарч буй иргэдийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийн радио станцыг байгуулах, НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран сургууль завсардсан хүүхдүүд болон насанд хүрсэн малчин иргэдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, амьдрах ухаанд сургах, ДЭМБ үндэстэн/угсаатны цөөнх хүн амын дундах эрүүл мэндийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр сургалт явуулах замаар ороэ эутаг дах бизнесийн хөгжлийг дэмжих үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготойгоор ажиллаж байна. Үүний зэрэгцээ бичиг үсгийн болон амьдрах ухааны сургалт явуулснаар иргэдийн амьжиргаагаа дээшлүүлэх, орлогоо нэмэгдүүлэх үйлчилгээнд хамрагдах боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх юм.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, тэгш байдлыг хангахад бодитой хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэлтэй байна.



# Төслийн Удирдлага, зохицуулалтын бүтэц




Төслийн Удирдах Хороо нь Монгол Улсын Шадар сайдын 2009 оны 88 дугаар тушаалаар байгуулагдсан.

Үндэсний техникийн ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайдын 2010 оны 26 дугаар тушаалаар баталсан.



# Төслийн Удирдах Хороо

Дарга: D. Nyamjav, Chair and Deputy Chief of the Cabinet Secretariat of the Government of Mongolia

Дэд дарга: М.Биста, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Бээжин хот дах Суурин төлөөлөгчийн газрын Боловсролын асуудал хариуцсан ажилтан

Гишүүд:
Н.Хүрэлбаатар, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
Б.Мишигжав, БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
Л.Зориг, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дэд дарга
Ж.Сансар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын
Ц.Ням-Осор, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга
М.Сандаг-Очир, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлагын хэлтсийн ахлах референт
Ш.Бүүвээбаатар, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалтын хэлтсийн ахлах референт
Э.Цасчихэр, Увс аймгийн Засаг дарга
С.Хавал, Баян-Өлгий аймгийн Засаг дарга
Л.Цэрэнжав, Хөвсгөл аймгийн Засаг дарга
Ц.Жанлав, Дорнод аймгийн Засаг дарга
Г.Нямдаваа, Ховд аймгийн Засаг дарга
С.Дэмбэрэл, Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга
М.Наранбаатар, Монголын олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал
Ш.Нода, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Шадар суурин төлөөлөгч
Р.Виват, ДЭМБ-ын Суурин төлөөлөгч
Ж.Фагниноу, НҮБ-ын Хүүхдийн сангийн Шадар суурин төлөөлөгч

Нарийн бичгийн дарга:
Ш.Нарантуяа, Шадар сайдын зөвлөх
Ц.Бужин, Төслийн үндэсний зохицуулагч



## Төслийн үндсэн зорилго

**Монгол улсын алслагдмал хөдөөгийн хүн амын нийгэм, эдийн засгийн нөхцлийг тогтворжуулах замаар тэдний амьдралын баталгааг дээшлүүлэхэд оршино.**

| | Төслийн бүрэлдэхүүн | Төсөв (ам.доллар) | НҮБ-ын холбогдох байгууллага |
|---|---|---|---|
| 1 | Мэдээлэл, харилцаа | 520,000 | ЮНЕСКО |
| 2 | Дуйцэх хөтөлбөр, бичгийн үсгийн болон амьдрах ухааны сургалт | 847,500 | ЮНЕСКО<br>НҮБ-ын Хүүхдийн сан |
| 3 | Эрүүл мэнд | 599,200 | ДЭМБ |
| 4 | Өрхийн амьжиргаа дэмжих | 529,458 | НҮБ ХХ |
| 5 | Бодлогын дэмжлэг | 296,000 | ЮНЕСКО |
| 6 | Нийт төсөв | 2,989,000 | |

Хугацаа: 2009 оны 6 дугаар сараас 2012 оны 5 дугаар сар хүртэл

## Бид юу хийх вэ?

Бүрэлдэхүүн хэсэг 1

### Хөдөөгийн хүн ам ялангуяа үндэсний / хэлний цөөнхийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх

1.1: Орон нутгийн телевиз, радиогийн нэвтрүүлэг дамжуулах чадавхийг нэмэгдүүлэх

1.2: Угсаатны цөөнх хүн амын хэл, соёлын үнэ цэнийг хадгалах зорилгоор тэдэнд өөрийн хэлээр унших, үзэх боломжоор хангах





Хамтрагч байгууллагууд:

Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
Харилцаа холбооны зохицуулах хороо
Радио, телевизийн сүлжээний газар
Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
Глоб Интернэйшнл ТББ
Монгол Улсын Их сургууль



## Бид юу хийх вэ?

Бүрэлдэхүүн хэсэг 2

### Хөдөөгийн хүн амын албан болон албан бус боловсролын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх

2.1: Хөдөөгийн хүн амд зориулсан албан бус боловсролын болон мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нутгийн иргэдийн сургалтын төв байгуулан улмаар бичиг үсгэт тайлагдалтын хувийг нэмэгдүүлэх

2.2: Сургууль завсардсан хүүхдүүдийг дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулан, сургуульд эргэж ороход нь дэмжлэг үзүүлэх

2.3: Малчин өрхийн бага насны хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх






Хамтрагч байгууллагууд:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв
Боловсролын хүрээлэн
Аймгийн Боловсрол, соёлын газар
Сумын сургууль



# Бид юу хийх вэ?

Бүрэлдэхүүн хэсэг 3

## Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

3.1: Эрүүл мэндийн ажилтнуудын эрүүл мэндийн анхан шатны тусламжийн талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэх

3.2: Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, мэдээлэл сургалт сурталчилгааны материал боловсруулах замаар угсаатны цөөнхийн дундах эрүүл мэндийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлнэ

3.3: Сумын эмнэлгийн усан хангамж, эрүүл ахуйн нөхцөл байдлыг сайжруулах, хог хаягдлын менежментийн тогтолцоог сайжруулах





Хамтрагч байгууллагууд:

Эрүүл мэндийн яам
ЗГХА – Эрүүл мэндийн газар
Аймгийн Эрүүл мэндийн газар
Сумын эмнэлэг



# Бид юу хийх вэ?

Бүрэлдэхүүн хэсэг 4

## Сонгосон аймгуудын хөдөөгийн хүн амын өрхийн орлогыг нэмэгдүүлэх болон амьжиргааг дээшлүүлэх боломжийг нэмэгдүүлэх

4.1: Сонгогдсон аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн өөрсдийн бизнесээ эхлүүлэх, орлого олох үйл ажиллагаа эрхлэх чадавхийг нэмэгдүүлэх

4.2: Бизнес менежмент, зах зээл, мэдээлэл түгээлт ба холбогдох үйлчилгээнд зориулагдсан орон нутагт нийцтэй бизнесийг дэмжих үйлчилгээний чанарыг сайжруулах

4.3: Сонгогдсон аймгуудад одоогийн бизнесийг дэмжих үйлчилгээгээр ажиллаж буй байгууллагуудын уялдаа холбоог орон нутгийн түвшинд сайжруулахад дэмжлэг үзүүлэх





Хамтрагч байгууллагууд: Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
Жижиг, дунд үйлдвэрийн газар
Ховд, Увс аймгийн худалдаа, аж үйлдвэрийн салбар танхим



# Бид юу хийх вэ?

Бүрэлдэхүүн хэсэг 5

## Хөдөө орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын цогц баримт боловсруулах ба бодлого хэрэгжүүлэх орон нутгийн засгийн газрын ажилтнуудын чадавхийг нэмэгдүүлэх

5.1: Хөдөөгийн хөгжлийн тогтвортой байдлын талаарх одоогийн бодлогод үнэлэлт дүгнэлт өгч, хийдлийг тодорхойлох

5.2: Гол бодлого боловсруулагчдын хандлага, мэдлэгийг дээшлүүлэх

5.3: Мэдээллийг ашиглан Засгийн газрын нотолгоонд тулгуурлан шийдвэр гаргах чадавхийг нэмэгдүүлэх





Хамтрагч байгууллагууд:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Шадар сайдын ажлын алба
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо
Аймгийн Засаг даргын тамгын газар

# Бид хаана ажиллах вэ?







# Бид ямар үр дүнд хүрэх вэ?

Үндэстэн/угсаатны цөөнх хүн амын мэдээлэл авах боломж, хүртээмж нэмэгдэнэ.

Албан болон албан бус боловсролын хүрээнд дүйцэх хөтөлбөр, бичиг үсгийн болон амьдрах ухааны сургалт зохион байгуулагдаж, эмзэг өрхийн хүүхэд болон гишүүд үр шимийг хүртэнэ.

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ сайжирч, эх, нялхсын эндэгдэл буурна.

Үндэстэн/угсаатны цөөнх хүн ам өрх орлогоо нэмэгдүүлэх ба амьдрах ухааны талаар мэдлэгтэй болж, санхүүгийн зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх боломж дээшилнэ

Хөдөө орон нутгийн тогтвортой хөгжлийн талаарх бодлогын зөвлөмж гарч, орон нутгийн засаг захиргааны байгууллагын нотолгоонд тулгуурлан шийдвэр гаргах чадавхи сайжирна




## Төслийн ажлын алба

**Төслийн үндэсний зохицуулагч Ц.Бужин**
Хаяг: Засгийн газрын III байр, Өрөө №107, Бага тойруу 44, Улаанбаатар, Монгол Улс
Утас/Факс: (51) 26 61 31
И-мэйл: b.tserensodnom@unesco.org

**ЮНЕСКО-гийн Мэдээлэл, харилцааны асуудал хариуцсан зөвлөх Б.Лутаа**
Хаяг: Засгийн газрын III байр, Өрөө №107, Бага тойруу 44, Улаанбаатар, Монгол Улс
Утас/Факс: (51) 26 61 31
И-мэйл: lutaa.b@gmail.com

**ЮНЕСКО-гийн Төслийн ажилтан Л.Оргилмаа**
Хаяг: Засгийн газрын III байр, Өрөө №107, Бага тойруу 44, Улаанбаатар, Монгол Улс
Утас/Факс: (51) 26 61 31
И-мэйл: o.luvsandash@unesco.org

**Т.Хантулга, БСШУЯ-ны харъяа Албан бус боловсрол, зайны сургалтын төвийн мэргэжилтэн**
Хаяг: Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай, Засгийн газрын X байр, Улаанбаатар, Монгол Улс
Утас: (11) 311022
Факс: (11) 324344
И-мэйл: khantulga@nfde.mn
Веб: www.nfde.mn

**НҮБ-ын Хүүхдийн сангийн Хөтөлбөрийн зохицуулагч Б.Болорчимэг**
Хаяг: Өрөө №410, Ориент Плаза, Г.Чагдаржавын гудамж 9, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Улаанбаатар-14210, Монгол Улс
Утас/Факс: (11) 31 21 83-108
И-мэйл: bbor@unicef.org

**НҮБ-ын Хүүхдийн сангийн Албан бус боловсролын асуудал хариуцсан зөвлөх Б.Халиун**
Хаяг: Өрөө №406, Ориент Плаза, Г.Чагдаржавын гудамж 9, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Улаанбаатар-14210, Монгол Улс
Утас/Факс: (11) 31 21 83-124
И-мэйл: kbatmunkh@unicef.org

**ДЭМБ-ын төслийн ажилтан Б.Алтанзагас**
Хаяг: ДЭМБ-ын “Эрүүл мэндийн анхан шатны тусламж ба ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн төсөл”, Шастины нэрэмжит төв эмнэлэг, Ард Аюушийн гудамж-1а, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Улаанбаатар, Монгол Улс
Утас: (11) 70178085
Факс: (11) 70179095
И-мэйл: badrakha@wpro.who.int

**ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Гангэрэл**
Хаяг: Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж-2, Улаанбаатар 48, Монгол Улс
Утас: (51) 263941, 99048678
Факс: (11) 320916
И-мэйл: gangerel_mn@yahoo.com
Веб: www.moh.mn

**НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ажилтан П.Цэцгээ**
Хаяг: Өрөө №609, Ориент Плаза, Г.Чагдаржавын гудамж 9, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Улаанбаатар-14210, Монгол Улс
Утас/Факс: (11) 327585-220
И-мэйл: tsetsgee.puntsag@undp.org

**Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэд дарга М.Оюунчимэг**
Хаяг: Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын байр, Өрөө 401, М.Гандигийн гудамж, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар 17011, УБ Шуудан -17011, Монгол Улс
Утас: (11) 324489
Факс: (11) 324620
И-мэйл: oyunchimeg.m@mongolchamber.mn
Веб: www.mongolchamber.mn